



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 01

Чолбалсан

Г Ой, хээрийн гал түймрээс урьдчилан  
сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", "б", 29.1.6 "л", 30 дугаар зүйлийн 30.1.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, 16.2.4, Гамшгаас хагаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилтын 22.14, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар баримтлах бодлого", аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3 дахь заалтуудын дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, гал түймэр унтраах ажиллагаанд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг бүрэн хангах, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг сайжруулах, ажлын чанар үр дүнг дээшлүүлж, уялдаа холбоог сайжруулах бэлэн байдлыг хангах зорилгоор дараах байгууллагууд, аж ахуйн нэгжүүдэд ДААЛГАХ нь:

Нэг. Аймгийн онцгой комиссын гишүүн,  
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад:

1.1. Ой, хээрийн түймрийн аюултай улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал, зугаалгаар явах зэрэг арга хэмжээнд байгаль хамгаалагч, мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалт хийж, галын аюулгүй байдлыг хангаагүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлж ажиллах,

1.2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалах шороон болон халз зурвасыг шинээр татах, сэргээх, ойн цэвэрлэгээ хийх ажлыг сум, орон нутаг, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдтэй хамтран зохион байгуулах,

1.3. Ойн сан бүхий газар нутаг, Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах багаж, хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж заавар зөвлөмж, үүрэг даалгавар өгөх,

/My computer D/ Alban daalgawar

01:320095

1.4. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар тусгасан ажлын биелэлтэд хяналт тавих,

1.5. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтамжтайгаар явуулж, урьдчилан сэргийлэх ажилд сум дундын ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, иргэдийн оролцоог хангах,

1.6. Сумын байгаль хамгаалагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хариуцсан нутаг дэвсгэртээ ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг өгч, хяналт тавьж ажиллах,

1.7. Ой, хээрийн түймрийн улмаас шатсан газрын судалгааг гаргаж, мэдээллийн санг бүрдүүлэх,

Хоёр. Аймгийн онцгой комиссын гишүүн,  
Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргад:

2.1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хуурайшилтын зэрэглэлийг тогтмол гаргаж, иргэд олон нийтэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг телевиз, радио, олон нийтийн сүлжээгээр сурталчлах ажлыг зохион байгуулах,

2.2. Хуурайшилтын зэрэглэл "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, бэлэн байдлыг хангах,

2.3. Аймгийн нийт нутгийн хуурайшилтын зэрэг, гантай үеийн мэдээлэл, судалгааг нэгтгэн боловсруулж, зураглал гарган тухай бүрт холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдээлж, иргэдэд багц мессеж үйлчилгээгээр анхааруулга сэрэмжлүүлэг өгч, ажиллах,

Гурав. Аймгийн онцгой комиссын орлогч дарга,  
Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын даргад:

3.1. Ой, хээрийн түймрийг унтраах техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгсэл, бие бүрэлдэхүүний тусгай хувцас хэрэгсэл, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, түймрийн үед Гамшгаас хамгаалах албад, Мэргэжлийн ангиудыг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт хүн, хүч хэрэгслийн дайчилгааг хуулийн хүрээнд зохион байгуулах,

3.2. Хилийн болон Зэвсэгт хүчний анги, орон нутгийн Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд ой, хээрийн түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулах,

3.3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, сэрэмжлүүлгийг давтамжтайгаар явуулах, гарсан түймрийг богино хугацаанд унтрааж, цагийн байдлыг тухай бүр нь мэдээлэх,

3.4. Хөрш зэргэлдээх орнуудын муж, аймгуудтай хил орчмын ой, хээрийн түймрийн үе дэх харилцан ажиллагааг тодотгох, хамтран дадлага сургууль зохион байгуулах

3.5. Ой, хээрийн түймрийн тохиолдол бүртгэж, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нэгтгэж, судалгаа гаргаж, холбогдох байгууллагад мэдээлэх,

3.6. Ой, хээрийн түймэр гарсан тохиолдол бүрт Гал түймрийн улсын хяналтын байцаагч томилж, түймэр гарсан шалтгаан, нөхцлийг шуурхай тогтоож, аймгийн Онцгой комиссын даргад танилцуулах.

3.7. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, гал түймрийн улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

Дөрөв. Аймгийн онцгой комиссын гишүүн,  
Цагдаагийн газрын даргад:

4.1. Ой, хээрийн түймрийн тохиолдол бүрийг хуулийн хугацаанд шуурхай шалгаж, эзэн холбогдогч, шалтгаан нөхцөлийг тогтоож, гэм буруутай иргэн, хуулийн этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага хүлээлгэн олон нийтэд мэдээлж ажиллах,

4.2. Цаг агаарын хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед аймаг, сумаас гарах замуудад эргүүл, хяналт, шалгалтын цэгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллуулж, ногоон бүсэд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, автомашин, техникийн дайчилгааг хуулийн дагуу зохион байгуулах,

4.3. Ой, хээрийн түймрийн үед автомашин, техникийн дайчилгааг хуулийн дагуу зохион байгуулах,

Тав. Аймгийн онцгой комиссын гишүүн,  
Мэргэжлийн хяналтын газрын даргад:

5.1. Ой, хээрийн түймрийн хэрэг, зөрчлийг хуулийн хугацаанд шуурхай шалган шийдвэрлэж, эзэн холбогдогч, шалтгаан, хохирлыг тогтоож, гэм буруутай иргэн, хуулийн этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага хүлээлгэж ажиллах,

5.2. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлын актыг шуурхай, бодитойгоор тогтоох,

5.3. Ой, хээрийн түймрийн аюултай улиралд мод бэлтгэл, ойн дагалт баялгийн ашиглалтад хяналт, шалгалт зохион байгуулж ажиллах,

Зургаа. Аймгийн онцгой комиссын гишүүн,  
"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн захиралд:

6.1. Ой, хээрт байрлах цахилгаан дамжуулах агаарын шугамуудад жилд 2 удаа буюу 2019 оны 03 дугаар сарын 20, 09 дүгээр сарын 20-ны өдрийн өмнө үзлэг, шалгалтыг зохион байгуулж, техник ашиглалтын шаардлагыг хангуулах,

6.2. Ой, хээрт байрлах Цахилгаан дамжуулах агаарын шугам, Дэд станцуудад засвар үйлчилгээ, гагнуур хийхдээ галын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах,

Долоо. Сумын онцгой комиссын дарга, сумын Засаг дарга нарт:

7.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хуулиуд, Засгийн газрын 2013 оны "Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам" 106 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх,

7.2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой, шинэлэг ажлуудыг хариуцсан нутаг дэвсгэр, баг бүрт зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, сурталчилгааг явуулж, дайчлагдан ажиллах малчид иргэдийг өөрийгөө хамгаалах, түймэр унтраах ажиллагаанд сургах,

7.3. Хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан түймрийг илрүүлэх, шуурхай мэдээлэх, унтраах зорилгоор сум орон нутгийн хэмжээнд өндрийн харуул, хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэгийг байгуулж, урамшуулалт эргүүлийг ажиллуулах, тэдгээрийг автомашин, техник, холбооны хэрэгсэл, шатахуунаар хангах,

7.4. Ойн тухай хуульд заасан ой, хээрийн түймрийн аюултай үе буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд түймрийн хариуцлагатай жижүүрийг 24 цагаар томилон ажиллуулж, аймгийн Онцгой байдлын газрын 7058101, 70584453 дугаарын утсаар 10:00, 16:00 цагуудад цагийн байдлыг тогтмол мэдээлж ажиллах,

7.5. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган баталж, түймэр унтраахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, түймэрт дайчлагдсан иргэд, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслийг шинээр бэлтгэж, нөөц бүрдүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаж, зарцуулах,

7.6. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, түймэр унтраах 1, 2 дугаар бүлгийг тус бүр 12-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилж, бэлэн байдлыг хангуулах, зэргэлдээх аймаг, сумын хилийн зааг дээр гарсан түймрийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй хамтран унтрааж, ажиллах,

7.7. Малчин өрхүүдийг бүлэг, багийн зохион байгуулалтад оруулж, түймрээс хамгаалах зурвас татах ажлыг ил гал гаргалгүй хийж, түймэр унтраах багаж, хэрэгслийг хамтран бүрдүүлж, урьдчилан сэргийлэх ажилд малчин иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

7.8. Ой, хээрийн түймрийн улмаас учирсан хохирлыг арилгах, учирч болох эрсдэлийг багасгахад чиглэсэн эд хөрөнгө, амь насны даатгалд иргэд, малчдыг хамруулах аян зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангаж, ач холбогдлыг ойлгуулах,

7.9. Ой, хээрийн түймрийн эзэн холбогдогч тогтоогдсон тохиолдолд гэм буруутай иргэн, хуулийн этгээдээр учирсан хохирлыг төлүүлэх, төлүүлэхээр иргэний журмаар Шүүхэд нэхэмжлэх,

7.10. Ой, хээрийн түймрийн улмаас байгаль орчинд болон иргэн аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын дагуу шуурхай гаргаж хууль, хяналтын байгууллагад нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх.

7.11.Сумын нутаг дэвсгэрт зам тавих, уул уурхайн үйл ажиллагаа, барилга, байгууламж барих, хадлан, газар тариалан эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагатай ой, хээрийн түймэр гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах,

7.12.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг "Багц мессеж" үйлчилгээг ашиглан түймрийн аюултай улирал эхлэхээс өмнө явуулж эхлэх, түүнд шаардагдах зардлыг оны эхэнд шийдвэрлэх,

7.13.Ой, хээрийн түймэр унтраахаар ажиллаж буй Онцгой байдлын байгууллагын албан хаагчдыг шатах, тослох материал, хоол хүнсээр ханган хамтарч ажиллах,

7.14.Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тогтоох ажлыг түймэр унтарснаас хойш 30 хоногийн дотор зохион байгуулах,

Найм. Зэвсэгт хүчний 0327 дугаар ангийн захирагчид:

8.1.Ангийн бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Онцгой байдлын газартай хамтран сургалт, дадлагын ажлыг зохион байгуулах,

Ес. Хилийн ангиудын захирагч нарт:

9.1.Анги, салбар, боомтуудад ой, хээрийн түймэрт хүч нэмэгдүүлэн ажиллах томилгоот бүрэлдэхүүнийг тодотгон Онцгой байдлын газартай хамтран сургаж, дадлагажуулах, түймэр унтраах багаж, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах,

9.2.Хилийн застав, боомт, хариуцсан хэсгүүдэд ой, хээрийн түймрээс хамгаалах зурвас татах ажлыг ил гал гаргалгүй хийх,

9.3.Монгол Улсын хил орчимд гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум орон нутагт шуурхай мэдээлж, гарсан гал түймрийг цаг алдалгүй унтраах, арга хэмжээг хамтран зохион байгуулах,

9.4.Хил дамнан орж ирсэн болон хил давж гарсан ой, хээрийн түймрийн талаархи мэдээллийг аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газарт албан бичгээр тухай бүрт ирүүлэх,

9.5.Анги, салбар боомтуудын тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, галын аюулгүй байдлыг хангуулж, алба хаагчдад хавар, намрын хуурайшилттай улиралд галын аюулгүй байдлыг хангаж, үүрэг гүйцэтгэх зааварчилгааг тогтмол өгч, ажиллуулах,

Арав. Ард иргэдэд уриалах нь:

10.1.Ой, хээрийн болон ахуйн гал түймрийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор газар нутаг өөрсдийн гэр, орон сууцныхаа галын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ой хээрийн түймрийн үед холбогдох төрийн байгууллагатай нягт уялдаа холбоотой хамтран ажиллаж, газар нутаг, хувийн эд хөрөнгө, мал, амьтан, бэлчээрээ хамгаалан сонор сэрэмжтэй байх,

Арван нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:

11.1. Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн хэрэгжилт, санхүүжилтийн талаар 2020 онд байгуулсан гэрээг дүгнэхдээ гамшгаас хамгаалах талаар тусгасан заалт бүрийг хянаж, сумандаа ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, ой, хээрийн түймэр гаргаагүй, түймэр гарсан тохиолдолд хэрхэн шуурхай унтраасан байдлыг шалгуур үзүүлэлт болгож дүгнэх,

Арван хоёр. Бусад хяналт, шалгалт

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж, зохион байгуулсан ажлын тайланг 2020 оны 06 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга, холбогдох байгууллагуудын удирдлагад, хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн 2020 оны 06 дугаар сарын 25, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Онцгой комисст танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын орлогч даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН